

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН
ХЭЛЭЛЦЭЭРҮҮД /УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ,
ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ/-ИЙН ЗӨВШИЛЦӨХ
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд /Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл/-ийг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, мал эмнэлгийн чадавх, материаллаг баазыг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн олон улсын байгууллагуудаас санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн бэлчээрийн чиглэлийн мал аж ахуйг хөгжүүлэх, малчдын ахуй орчинг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор төсөл хэрэгжүүлэх газар нутгийн шалгуур үзүүлэлтийг хэрхэн сонгосон талаар асуулт асууж, тодруулга авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төслийн хүрээнд хийгдэх ажлууд нь төсвийн урсгал зардлаар санхүүжигдэх боломжтой тул зээл авч улсын өрийг нэмэгдүүлэх шаардлага байгаа эсэхийг анхаарч, төслийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн болон зээл ашиглалтын тооцоог нарийвчлах зорилгоор төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.


Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд /Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл/-ийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд /Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл/-ийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ч.ХҮРЭЛБААТАР